



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 7 сарын 01 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Г Нийслэлийн өмчид 9 барилга байгууламж Т
бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, байгууллагын өөрийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон нийт 120,700,300,631.67 (нэг зуун хорин тэрбум долоон зуун сая гурван зуун мянга зургаан зуун гучин нэгэн төгрөг жаран долоон мөнгө) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан 9 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА  Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 32
дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАЛСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	262 дугаар цэцэрлэгийн барилга	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Энгельсийн гудамж, Нарны хороолол	2017	5,253,793,120.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
2	141 дүгээр сургуулийн барилга	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Энгельсийн гудамж, Нарны хороолол	2017	13,190,179,880.00	
3	Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилга	Сонгинохайрхан дүүрэг, 19 дүгээр хороо, 21 дүгээр хороолол, Үйлдвэрчний эвлэлийн гудамж	2021	88,974,398,337.00	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл
4	Сонгинохайрхан дүүргийн Нутгийн захиргааны нэгдсэн байрны барилга	Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, Баянголын гудамж	2022	6,538,599,069.67	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
5	Сонгинохайрхан дүүргийн Ахмадын өргөөний барилга	Сонгинохайрхан дүүрэг, 1 дүгээр хороо, Буман өлзий хотхоны баруун талд	2021	745,644,443.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
6	68 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга	Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, 5 дугаар хороолол	2021	1,433,760,531.00	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл
7	Монгол–Оросын хамтарсан сургуулийн Номын сан, соёл урлагийн танхимын өргөтгөлийн барилга	Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, 5 дугаар хороолол	2022	2,489,100,001.00	Өөрийн хөрөнгийн эх үүсвэр

8	Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн барилга	Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Үйлдвэр, Туул гол гудамжны 63а байрны нэгдүгээр давхрын 3 тоот	2021	915,519,000.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
9	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 24 дүгээр хорооны иргэдэд үйлчлэх байр	Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, Вива сити хорооллын 2/16 байрны 1-1-4 тоот	2022	1,159,306,250.00	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
НИЙТ ДҮН				120,700,300,631.67	

